



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2020 оны 5-р сарын 22-оос  
5-р сарын 29-ний байдлаар

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 5-р сарын 22-оос 5-р сарын 29-ний байдлаар

Шинэ хэлбэрийн Корона вирус (Ковид-19) дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн арван нэг дэх дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын тооцооллоор энэ оны **2-р улиралд** бүх насны ажилчдын **ажиллах цаг** 2019 оны сүүлийн улиралтай харьцуулахад **10.7 хувиар буурах буюу 350 сая ажлын байр алдагдсантай дүйцэхээр байна**. ОУХБ-ын 5-р сарын 27-ны тайланд дурдсанаар нийт түүвэр судалгаанд оролцсон 18-29 насны 6 хүн тутмын 1 нь Ковид-19-ийн улмаас ажлын байраа алдсан буюу Financial Times сэтгүүлийн тооцооллоор 200 сая гаруй залуус ажилгүй болжээ. Мөн ажилдаа үлдсэн хүмүүсийн ажлын цаг дунджаар 23 хувиар буурчээ.
- **Фитч агентлагаас** дэлхийн эдийн засаг 2020 онд 4.6 хувиар агших төсөөллийг 5-р сарын 26-нд шинэчлэн гаргав. Ингэснээр өмнөх сарын төсөөллийг 0.7 нэгж хувиар бууруулжээ. Үүнд Евро бүсийн төлөв өмнөх төсөөллөөс 1 гаруй нэгж хувиар, Хятадаас бусад эрчимтэй хөгжиж буй орнуудын өсөлт 2.6 нэгж хувиар муудсан нь голлон нөлөөлөв.

#### Хүснэгт 1. Фитч агентлагийн 2020 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Төсөөлөл хийсэн огноо	Дэлхийн эдийн засгийн өсөлт	Хятадын өсөлт	АНУ-ын Өсөлт	Евро бүс өсөлт
5/26/2020	<b>-4.6%</b>	0.7%	-5.6%	-8.2%

- **Ройтерс** агентлагаас 5-р сарын 27-ны өдөр 250 гаруй эдийн засагчдын дунд явуулсан санал асуулгаар **дэлхийн эдийн засгийн өсөлт 2020 онд дунджаар 3.2 хувиар агших (-0.3 хувиас -6.7 хувийн интервалтай) таамаглалыг гаргажээ**. Энэ нь 4-р сард явуулсан санал асуулгаас 1.2 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм.
- **Евро бүсийн эдийн засаг энэ онд 8-12 хувиар агшиж**, Ковид-19-ийн нөлөөгөөр хөрөнгийн урсгал татарч 2008-09 оны санхүү, эдийн засгийн хямралаас 2 дахин том эдийн засгийн хямрал нүүрлэж байгааг **Европын төв банкны тэргүүн Кристин Лагард онцоллоо**. Европын төв банк ирэх 7 хоногт хуралдаж бодлогын шийдвэр гаргана.

- **Евро бүсийн боловсруулах үйлдвэрлэлийн менежерийн индекс (PMI)** 4-р сард 33.4 байсан бол **5-р сард 39.5<sup>1</sup>** болов. Энэ нь үйлдвэрлэлийн агшилт алгуур буурч байгааг илэрхийлж байна. ОХУ-ын жижиглэн худалдаа 4-р сард өмнөх оны мөн үеэс 23 хувиар агшжээ. Мөн барилгын үйлдвэрлэл 2.3 хувиар, карго тээвэр 6 хувиар буурсан байна.
- **БНХАУ, АНУ хоорондын харилцаа хурцдаж, худалдааны хэлэлцээрт хүндрэл дахин үүсэв.** Ковид-19-ийн гарал үүсэлтэй холбоотой үл ойлголцол, Ковид-19-ийн цар хүрээ, эрсдэлийн талаар дэлхий нийтэд буруу ойлголт өгч, төөрөгдүүлсэн гэх АНУ-ын Ерөнхийлөгчийн мэдэгдэл, БНХАУ-ын Ардын Их Хуралд өргөн барьсан<sup>2</sup> “Хонконгийн аюулгүй байдлын тухай хууль” зэрэг нь хоёр улсын хоорондын маргаан хурцдах үндсэн шалтгаан болоод байна. АНУ-ын Засгийн газраас томоохон тэтгэврийн сангуудыг Хятадын компаниудад хөрөнгө оруулахыг түдгэлзүүллээ. Мөн Хонконгийг улс төрийн хараат бус байдлаа Хятадад алдлаа гэж АНУ үзэж байна. Улмаар Хятадын зарим компаниудын хөрөнгийг царцаах, АНУ-ын томоохон санхүүгийн корпорациуд Хонконгийн санхүүгийн захаас хөрөнгөө татах арга хэмжээ авч болохгүйг АНУ-ын Засгийн газар анхааруулж байна.
- АНУ, Хятад хоорондын худалдааны хэлэлцээрийн удаашралтай холбоотой **АНУ-ын түнш улс орнуудын дараалал өөрчлөгдөж байна.** Хоёр улсын хоорондын худалдааны маргаантай холбоотойгоор зарим компаниуд

Хятадад байрладаг үйлдвэрүүдээ ойролцоо орнууд уруу шилжүүлж эхлээд байсан бөгөөд таагүй харилцаа үргэлжилсэн тохиолдолд энэ нүүдэл нэмэгдэх хүлээлттэй байна. БНХАУ 2015-2018 онуудад АНУ-ын нийт импортын 21 хувийг эзэлж байсан бол 2019 онд 18 хувь болж буурчээ. Харин Хятадын оронд Мексик улс АНУ-ын хамгийн том худалдааны түнш орон болсон. Нөгөөтэйгүүр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид зарим үйл ажиллагаагаа Хятадаас Мексик уруу шилжүүлсэн бол хүн хүч их шаардагддаг үйлдвэрлэгчид үйл ажиллагаагаа Зүүн Өмнөд Ази, тэр дундаа Вьетнам уруу шилжүүлж эхэлсэн. АНУ-аас Хятадын 370 тэрбум ам.долларын бүтээгдэхүүнд 7.5-25 хувийн тариф тогтоогоод байгаа нь 2019 онд Хятадын нийт импортын 82 хувийг бүрдүүлж байна. АНУ-ын төмөр зам болон цахилгаан машин механизмын импортод Хятадын эзлэх хэмжээ 2018-19 онд 29, 36 хувиас тус тус 6 нэгж хувиар буурав. Харин АНУ-ын төмөр замын импортын Мексикийн эзлэх хэмжээ 2019 онд 7 нэгж хувиар нэмэгдэж 16 хувь, автомашины импортод эзлэх хэмжээ 2 нэгж хувиар нэмэгдэж 33 хувьд хүрээд байна. Гэхдээ дэлхийн боловсруулах үйлдвэрлэлийн салбар, тэр дундаа тоглоом, тавилга, хувцас, төмөр зам болон цахилгаан машин механизмын үйлдвэрлэлд БНХАУ-ын голлох хувийг эзэлсэн хэвээр байгааг Блүүмбергийн шинжээчид онцоллоо. Цаашид худалдааны маргаанаас гадна цар тахлын нөлөөгөөр үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж болзошгүй байна. Улс орнууд эрүүл мэнд, аюулгүй байдлаа

<sup>1</sup> IHS Market-с гаргадаг PMI индекс нь 50-с доош утгатай бол агшилт, 50-с дээш утгатай бол сэргэлтийг илэрхийлдэг.

<sup>2</sup> Уг хуулийн өргөн барьсан төслийг Хятадын Ардын Их Хурлын 5-р сарын 28-ны өдрийн

санал хураалтаар батлаад байна. Хуулийн нарийн заалт, агуулгыг ирэх саруудад шийдэх юм.

хамгаалах зорилгоор үйлдвэрлэлээ дотооддоо эргүүлж татах хандлага бий боллоо. Тухайлбал, Японы ЗГ-ын зүгээс үйлдвэрлэлийн салбарыг нутагшуулах зорилтыг дэмжих зорилготой татаас олгохоор болов.

- Японы ерөнхий сайд Шинзо Абэ 5-р сарын 27-ны өдөр сүүлийн 7 долоо хоногийн турш тогтоогоод байсан онц байдлыг цуцалснаар эдийн засгийн үйл ажиллагаа хэвийн горимд шилжиж эхлэв. Түүнчлэн Японы Засгийн газар 1.1 их наяд ам.долларын эдийн засгийг дэмжих шинэ багцыг батлаад байна. Үүний хүрээнд жижиг дунд бизнесүүдийг дэмжих, Ковид-19-ийн улмаас бэлэн мөнгөний дутагдалд орсон компаниудад дэмжлэг үзүүлэх, эмнэлгийн хэрэгсэл болон эмч сувилагчдын нэмэлт цалин хөлс, бага орлоготой өрхүүд, ХАА салбар, орон нутагт дэмжлэг олгох санхүүжилтүүд багтаж байна.

- **Fitch, S&P агентлагууд албан ёсоор Аргентины бондын дефолтыг зарлав.** Энэ нь тус улсын түүхэнд 9 дэх, сүүлийн 20 жилд 3 дахь дефолт болж байгаа юм. Эдийн засгийн хүндрэлийг давах зорилгоор Аргентин Улс 2018 онд ОУВС \$60 тэрбум орчим буюу түүхэн дээд хэмжээний санхүүжилтийн хөтөлбөрийг баталсан хэдий ч, хөрөнгө оруулагчдын итгэл сул, бондуудын үнэ унаж өгөөж өссөөр байв. Хөгжиж буй орнуудын гадаад өрийн нийлбэр 11 их наяд ам.доллар байгаагаас 2020 онд 3.9 их наяд ам.доллар буюу үүнээс \$3.5 их наяд ам.доллар нь үндсэн төлбөрийг төлөх хуваарьтай байна. Өнгөрсөн жилүүдэд худалдааны маргааны нөлөөгөөр түүхий эдийн үнэ ихээхэн савлагаатай байсны нөлөөгөөр гадагшилж эхлээд байсан хөгжиж буй орнуудаас гарах хөрөнгийн урсгалыг Ковид-19 эрчимжүүллээ. Улмаар Ковид-19 эхэлснээс хойш түүхэн рекорд 100 тэрбум ам.долларын гарах урсгал бий болсон бөгөөд хөгжиж буй орнуудын өрийн асуудал дэлхийн эдийн засгийн нэг гол сорилт, хүндрэл болж байна.

- Хятадын Ардын их хурал 5-р сарын 22-ны өдрөөс эхлэн хуралдаж 2020 оны эдийн засгийн гол зорилтуудыг хэлэлцэв. **2020 онд эдийн засгийн өсөлтийн тоон зорилт тавиагүй** бөгөөд төсвийн бодлого тэлэлттэй, харин мөнгөний бодлого уян хатан байхаар байна. Ерөнхий сайд Ли Кецянь Засгийн газраас ажлын байрыг хадгалах, иргэдийн амьжиргааг дэмжих бодлого амжилттай хэрэгжвэл эдийн засаг өсөх боломжтойг онцоллоо. Хэрэв нөхцөл байдал муудсан тохиолдолд Бээжингээс нэмэлт арга хэмжээг авна гэдгийг мэдэгдэв. Ардын Их Хурлын дараах хэвлэлийн хурлын үеэр Америктай харилцан хүндэтгэлтэй харилцаатай байх нь чухал бөгөөд 2 гүрний үл ойлголцол дэлхий нийтэд сайн нөлөө үзүүлэхгүй гэдэг байр суурийг илэрхийлэв.
- Хятадын төрийн өмчит компаниудын ашигт ажиллагаа 1-р улиралд өмнөх оны мөн үеэс 45.5 хувиар буурсан бол оны эхний 4 сард 46 хувиар буурч 4-р сарын аж үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны бууралтын дийлэнх хувийг тайлбарлаж байна. **Аж үйлдвэрлэлийн салбар дахь ашигт ажиллагаа 3-р сард өмнөх оны мөн үеэс 34.9 хувиар буурсан бол 4-р сард 4.3 хувиар агшиж, уналтын эрч сулрав.** Дотоод эрэлт алгуур сэргэж буй нөлөөгөөр хөрөнгө оруулалт болон жижиглэн худалдааны бууралт 4-р сард багассан нь эерэгээр нөлөөлөв. Гэхдээ дотоод болон гадаад эрэлт өмнөх хэвийн түвшинд хүрэх болоогүй байгаа тул оны 2-р хагаст төсөв, мөнгөний дэмжлэг үргэлжлэх шаардлагатай хэмээн үзэж байна. БНХАУ-ын үйлдвэрлэлийн үнийн индекс 4-р сард 2016 оны 2-р хагасаас хойших хамгийн их хэмжээгээр буурсан нь үүнийг нотолж байгаа хэрэг юм.
- **БНХАУ-ын нүүрсний нийт импорт** оны 4-р сард 30.9 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 22.1 хувиар **нэмэгдсэн бол** коксжих нүүрсний импорт 4-р сард 6.28 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 15.5 хувиар **буурсан** байна. Харин Австралиас импортолсон коксжих нүүрсний хэмжээ оны 4-р сард 4.47 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 64.9 хувь, ОХУ-аас импортолсон хэмжээ 605,145 тоннд, АНУ-аас импортолсон хэмжээ 91,661 тонн тус тус хүрч **нэмэгдсэн** бол Монгол Улсаас импортолсон хэмжээ 775,242 тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 79 хувиар **буурсан үзүүлэлттэй байна.**
- **БНХАУ-ын Засгийн газар** дотоодын нүүрсний үйлдвэрлэлээ дэмжиж, **эрчим хүчний нүүрсний импортоо бууруулах төлөвтэй байна.** Хятадын эрчим хүчний нүүрсний импорт оны 4-р сард 14.5 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 88.9 хувиар нэмэгдсэн бол оны эхний 4 сард эрчим хүчний нүүрсний нийт импорт 55 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 69.1 хувиар нэмэгдлээ. Австралийн эрчим хүчний нүүрсний импорт оны эхний 4 сард өсөлттэй байсан бол 5-р сарын сүүлийн 2 долоо хоногт 41 хувийн бууралт ажиглагдлаа. Энэ онд Хятадын Засгийн газраас нүүрсний импортын зорилт тавиагүй боловч өмнөх жилийн 280 сая тонн орчимд хадгалах төлөвтэй гэж салбарын удирдлагууд үзэж байна.
- Ковид-19-өөс шалтгаалан эрэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаа хэдий ч, Хятадын дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн, импортын хоригоо чангаруулсан болон байгаль орчны хамгааллын хүрээнд зарим мужуудад үйлдвэрлэлээ бууруулахыг уриалсантай

холбоотой нүүрсний үнэ бага зэрэг нэмэгдэх хандлагатай байгааг SXCoal мэдээлэв.

- **Хятадын төсвийн бодлого:** Хятадын Ардын Их Хурлаар төсвийн алдагдлыг 2020 онд нэмэгдэж 3.6 хувьд хүргэхээр баталлаа. Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бондын арилжаа болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авснаар 2020 онд Хятадын Засгийн газар 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийх төлөвтэй байна. Хятадын Засгийн газраас 2-6-р саруудад ойролцоогоор 650 тэрбум юанийн хөнгөлөлтийг компаниудад олгохоор байна. Эдийн засгийг дэмжих багцын хүрээнд ААН-үүдийн татварын хөнгөлөлт 2.5 их наяд юань, Ковид-19-ийн эсрэг тусгай зориулалтын бонд 1 их наяд юань, мөн орон нутгийн бондын квотыг 3.75 их наяд юаниар тогтоов. Энэ нь нийтдээ ДНБ-ий 4.6 хувьтай тэнцэхээр байна. Тогтворжуулах сан болон бусад сангууд нэгдсэн төсвийн орлогыг 3.0 их наяд юаниар нэмэгдүүлж байна<sup>3</sup>. Эдгээр хэсгийг нэгдсэн орлогоос хасч тусгай зориулалттай бондын хэмжээ болох 4.75 их наяд юанийн зарцуулалтыг оруулан тооцоход төсвийн алдагдал батлагдсан 3.6 хувиас илүү ДНБ-ий 6.5-11 хувьд хүрэхээр байна гэж Блүүмбергийн шинжээчид дүгнэв. Түүнчлэн цэргийн зардал 2020 онд 6.6% өсөхөөр байна.

<sup>3</sup> Үүнээс төрийн өмчит компаниудын орлого 358 тэрбум юань, Засгийн газрын тогтворжуулах сан 530 тэрбум юань, орон нутгийн захиргаанд зориулсан сангууд 2.1 их наяд юанийг бүрдүүлэхээр байна. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд төсвийн нэгдсэн орлогод 2018 онд 285.3 тэрбум юань, 2019 онд 1.51 их наяд юанийн орлого оруулж байв.

**Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Их хурлаар инфляцийн зорилтыг 2020 онд 3.5% гэж тогтоосон бөгөөд мөнгөний бодлогоор эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалаад уян хатан бодлого явуулна гэдгийг мэдэгдэв. Хятадын Ардын Банк (ХАБ) энэ онд дэлхийн эдийн засгийн хямралаас үүдэн дотоод эдийн засагт ирэх дарамтыг саармагжуулахын тулд бодлогын хүүгээ 0.5-0.6 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байна<sup>4</sup>. Энэ оны 2-р улиралд бодлогын хүүг дахин 0.2 нэгж хувиар бууруулна гэж Блүүмбергийн шинжээчид таамаглаж байна. Түүнчлэн, 4-р сарын 3-ны өдөр зарласан Заавал байлгах нөөцийн хувийг жижиг банкуудад 1 нэгж хувиар бууруулах шат дараатай бодлогын шийдвэр<sup>5</sup> 5-р сарын 15-аас хэрэгжиж эхэлснээр нийт 400 тэрбум юанийн эх үүсвэр чөлөөлөгдөв. Оны 5-р сарын эцэст татварын төлбөр төлөх улирал ойртож буйтай холбоотой банкны салбараас 350 тэрбум юань татагдах төлөвтэй хэдий ч, 6-р сараас Засгийн газрын цэвэр зарцуулалт нэмэгдэхээр байгаа тул хөрвөх чадварт нөлөө бага гэж үзэж байна. Мөн цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна.

<sup>4</sup> ХАБ өмнө нь бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байсан.


<sup>5</sup> ХАБ-аас 4-р сарын 3-нд Заавал байлгах нөөцийн хувийг 1 нэгж хувиар 2 үе шаттайгаар бууруулах шийдвэрийг гаргаж, эхний удаагийнх 4-р сарын 15-с хэрэгжиж эхэлсэн бол 2-р шат 5-р сарын 15-наас хэрэгжиж эхлэхээр байна.

### 3 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ГОЛЛОХ ИНДЕКС ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

#### USD, S&P:

- Тайлант хугацаанд DXY индекс 2 хувиар суларсан нь 3-р сараас хойш хамгийн ихээр суларсан үзүүлэлт юм. Вирусийн эрсдэл буурч байгааг харгалзан дэлхий даяар хөл хориог аажмаар цуцалж байна. Улмаар хөрөнгө оруулагчид бэлэн ам.долларын хөрөнгө оруулалтаа бууруулж байгааг ханшийн сулрал, хувьцааны өсөлт илтгэж байна.
- Нөгөө талаас БНХАУ-тай харилцах харилцаа эргэн муудсан, олон хотуудад жагсаал цуглаан дэгдсэн зэрэг нь эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай байна. Улмаар эрсдэл бага хэрэгсэл болох алтны ханш өссөөр байна.
- Үүнээс харахад эрсдэлийн хөдөлгөөнийг зах зээлд оролцогчид хараахан тодорхойлох боломжгүй байна.

Дүрслэл 1: Алт, S&P 500, ам.долларын индекс



#### GBP, FTSE:

- Тайлант хугацаанд фунт стерлинг ам.долларын эсрэг 0.2 хувиар суларч,

1.23 түвшинд хүрлээ. Эдийн засаг 2 хувиар агшсан нь ханшид сөрөг нөлөө үзүүлэв.

#### CNY:

- Тайлант хугацаанд юань ам.долларын эсрэг 0.7 хувиар сулран, 7.14 түвшинд хүрлээ.
- Хонконгийн асуудлаас шалтгаалан АНУ-тай харилцаа таарамжгүй байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж, 7.17 хүртэл буюу сүүлийн 8 сарын хамгийн их хэмжээгээр сулрахад хүргэлээ. Мөн хувьцааны индекс 3.5 хувиар буурлаа.
- Ханшийг тогтвортой түвшинд барих зорилгоор ХАБ-наас юанийн ханшийг аажмаар чангаруулж байна.

#### JPY, Nikkei:

- 5-р сарын 11-ээс хойш иен ам.долларын эсрэг 107 түвшинд байсаар байгаа нь сүүлийн 100, 200 өдрийн дундаж ханш болох 108-аас чанга байсаар байна. Ам.долларын ханш тайлан хугацаанд суларсан нь мөн нөлөөлөв.
- Макро эдийн засгийн орчин суларсан хэдий ч хувьцааны зах 11.2 хувиар сэргэхэд БНХАУ-ын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа эргэн нээгдэж, PMI индекс 50- аас дээш байгаа нь нөлөөллөө.

#### EUR:

- Тайлант хугацаанд евро ам.долларын эсрэг 2.5 хувиар чангарч, 1.11 түвшинд хүрэв.
- Эдийн засгийн өсөлтийг дэмжих 500 тэрбум еврогийн багц хөтөлбөр хэрэгжүүлэхээр болсон нь ханшийн өсөлтөд эерэгээр нөлөөлөв.

**4 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ**

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн ажлын хэсэг 2020 оны 5 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Монгол Улсын эрх баригчидтай цахим уулзалт зохион байгуулав. Уулзалтын үеэр Ковид-19 цар тахлын Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй нөлөө, өрийн тогтвортой байдал болон бусад асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлсэн. Улмаар, уулзалтын дараа Шуурхай санхүүжилтийн хэрэгсэлд Монгол Улсыг хамруулах хүсэлтийг хэлэлцэж, төсвийн болон төлбөрийн тэнцлийн яаралтай төлбөрүүдийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 72.3 сая зээлжих тусгай эрх буюу 99 сая ам.долларын санхүүжилт олгохоор ажлын хэсгийн түвшинд тохиролцоонд хүрлээ. ОУВС-аас мэдээлж байгаагаар 6-р сарын эхээр тус асуудлыг ОУВС-гийн захирлуудын зөвлөлөөр хэлэлцэж эцэслэн шийдвэрлэх юм.

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад орж, нийт 4 шууд хэрэгжилтийн зөвлөмж дээр 6 үүрэг даалгавар авсан.

Үүний хүрээнд Засгийн газраас байгуулагдсан ажлын хэсэг, Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодын хамтарсан ажлын хэсгүүд ФАТФ-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гарах чиглэлээр эрчимтэй ажиллаж, төлөвлөгөөнд тусгасан ажлуудтай холбоотой тайланг ФАТФ-ын Ази, Номхон Далай бүс хариуцсан хамтарсан бүлэгт цаг тухайд нь хүргүүлж ажиллалаа.

Улмаар 2020 оны 1-р сар болон 5-р саруудад холбогдох тайлангуудыг танилцуулж, амжилттай хамгаалсны үр дүнд Монгол Улс өгөгдсөн 6 ажлын үүрэг даалгавраа хангалттай биелүүлсэн гэдэг үнэлгээг ФАТФ-аас өгсөн байна. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын гаргасан ахиц, дэвшлийг үнэлэх үйл ажиллагааг газар дээр нь ирж шалгах арга хэмжээг авах бөгөөд үүний дараа ФАТФ-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гарах боломжтой юм.



## 5 ГОЛЛОХ ХҮҮ, БОНД, ОУ-Д АРИЛЖААЛАГДАЖ БУЙ МУ-ЫН БОНД, ХУВЬЦАА

### LIBOR:

- Вирусийн тархалтаас эдийн засгаа хамгаалах зорилгоор ХНБ-наас хэрэгжүүлж буй мөнгөний зөөлөн бодлогын хүрээнд LIBOR хүү бүх хугацаанд 0.18 нэгж хувь хүртэл буурав.

### АНУ-ЫН ЗГҮЦ:

- АНУ-ын Сангийн яам эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн 3 их наяд ам.долларын төсвийн зарцуулалт хийхээр төлөвлөөд байгаа билээ. Тус зардлыг хэрхэн санхүүжүүлэх асуудлаар ЗГҮЦ-ны зах зээл хүлээлт үүсгээд байна.
- Улмаар 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 0.65 хувьд, 2 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 0.16 хувьд тогтвортой байв.

### Хүснэгт 2: Голлох хүүгийн өөрчлөлт

Индекс	Сүүлийн хаалт	21 хоног Δ	1 сар Δ	1 жил Δ	Оны эх Δ
Fed Overnight	0.05	▲ 0.01	▲ 0.01	▼ -2.32	▼ -1.50
Libor 1 week	0.09	▼ -0.01	▼ -0.05	▼ -2.30	▼ -1.50
Libor 1 month	0.17	▼ -0.05	▼ -0.23	▼ -2.27	▼ -1.56
Libor 3 month	0.35	▼ -0.10	▼ -0.41	▼ -2.17	▼ -1.55
Libor 6 month	0.52	▼ -0.18	▼ -0.35	▼ -2.01	▼ -1.39
Libor 12 month	0.68	▼ -0.12	▼ -0.23	▼ -1.89	▼ -1.32
Shibor O/N	2.10	▲ 0.95	▼ -0.41	▼ -0.39	▲ 0.65
Shibor 1 Week	2.15	▲ 0.31	▼ -0.46	▼ -0.63	▼ -0.28
Shibor 1 Month	1.43	▲ 0.13	▼ -1.38	▼ -1.39	▼ -1.47
Shibor 6 Month	1.55	▲ 0.06	▼ -1.35	▼ -1.41	▼ -1.47
Shibor 1 Year	1.77	▲ 0.09	▼ -1.21	▼ -1.43	▼ -1.31
US 2Y Treasury	0.16	▲ 0.02	▼ -0.03	▼ -1.95	▼ -1.41
US 10Y Treasury	0.65	▲ 0.01	▲ 0.04	▼ -1.61	▼ -1.22
Japan 2Y Treasury	-0.16	▼ -0.01	▲ 0.00	▲ 0.01	▼ -0.03
Japan 10Y Treasury	0.00	▲ 0.00	▲ 0.03	▲ 0.09	▲ 0.02
Bund 2Y Treasury	-0.67	▲ 0.10	▲ 0.11	▼ -0.02	▼ -0.06
Bund 10Y Treasury	-0.45	▲ 0.10	▲ 0.14	▼ -0.27	▼ -0.22
ECNIA	-0.46	▲ 0.00	▲ 0.00	▼ -0.09	▼ 0.00

### SHIBOR:

- 6-р сард их хэмжээний өр эргэн төлөгдөхөөр хүлээгдэж байгаагаас үүдэн БНХАУ-ын санхүүгийн зах зээлд богино хугацаат санхүүжилтийн өртөг өслөө. Улмаар 7 хоногийн хугацаатай SHIBOR хүү 2.15 хүрч 1 жилийн хүүний түвшингээс ойролцоогоор 20 хувиар илүү байна.

### Бондын мэдээлэл:

- Тайлант хугацаанд Монгол Улсын гадаад бондуудын үнэ 14.7 хувь хүртэл өсч, өгөөж 7.1 хувь хүртэл буурав.
- Ам.долларын өгөөжийн түвшин тогтвортой байгаа гадаад зах зээлийн орчинд Монгол Улсын ам.долларын үнэт цаасны өгөөж буурч буй нь зээлийн эрсдэл буурч, хөрөнгө оруулалтын орчин сайжирч байгааг илтгэж байна.

### Хүснэгт 3: Дотоодын үнэт цаасны өөрчлөлт

Үнэт цаас	Сүүлийн хаалт	Өөрчлөлт Δ			
		14 хоног	Сар	Жил	Оны эх
ЗГҮЦ 5 жил	\$113.3	▲ 14.7%	▲13.8%	▲ 2.9%	▼ -6.3%
ЗГҮЦ 10 жил	\$95.2	▲ 6.3%	▲5.7%	▼ -4%	▼ -7%
ЗГҮЦ 5 жил (2021)	\$102.4	▲ 3.7%	▲2.9%	▼ -7%	▼ -6.3%
ЗГҮЦ 7 жил	\$100.8	▲ 5.1%	▲3.0%	▼ -8.8%	▲ 5.1%
ЗГҮЦ (Гэрэгэ)	\$95.1	▲ 6.9%	▲5.4%	▼ -4.0%	▼ -8.1%
ХБ 5 жил (2023)	\$92.0	▲ 6.6%	▲6.6%		
Turquoise hills (CAD)	\$0.7	▲ 37.9%	▲51%	▼ -38%	▼ -1.1%
ММС (HKD)	\$0.3	▼ -8.0%	▼ -18%	▼ -71%	▼ -47.7%
<b>Өгөөж</b>					
ЗГҮЦ 10 жил (Чингис)	7.3	▼ -2.60	▼ -2.29	▲ 1.76	▲ 3.07
ЗГҮЦ 5 жил (Мазаалай)	7.1	▼ -4.46	▼ -3.63	▲ 2.23	▲ 4.16
ЗГҮЦ 7 жил (Хуралдай)	8.5	▼ -1.58	▼ -0.94	▲ 2.31	▲ 3.50
ЗГҮЦ 6 жил (Гэрэгэ)	7.5	▼ -2.51	▼ -1.90	▲ 1.62	▲ 3.05
ХБ 5 жил (2023)	7.4	▲ 0.00	▲ 0.00		